

Маргааны товч:

Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч нараас 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн НА-25220000093 дугаар татварын нөхөн ногдуулалтын актаар “Эн Ти Эн Эйч Ди медиа групп” ХХК-д нөхөн төлбөр, торгууль, алданги төлүүлэхээр шийдвэрлэжээ.

Нэхэмжлэгчээс дээрх актыг эс зөвшөөрч, үндэслэлээ “татварын улсын байцаагч нар хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй, харилцааг буруу тодорхойлж, буруу хууль хэрэглэсэн. Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, эрх шилжүүлэх гэрээний тал, суутган төсөвт төлөх үүрэг бүхий этгээдийг зөв тодорхойлж чадаагүй. Гэрээний тал биш, орлого олсон этгээд биш байхад татварын суутган төлөгчийн үүрэг үүсэхгүй” гэж тайлбарлан маргажээ.